

**МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦООН ДАХЬ
ШУДАРГА БУС
БАЙДЛЫН ИЛРЭЛҮҮД БА
ЭЦЭГ ЭХЭЭС АВЧ БУЙ ТӨЛБӨР, ХУРААМЖ**



Эрхлэн гаргасан: Боловсролын Хамтын
Ажиллагааны Нийгэмлэг

Судлаачид: Б. Батжаргал, Д. Тунгалаг, Н. Энхтуяа
Редактор: Д. Тунгалаг, БНБТИНҮЭ

Хэвлэлийн дизайн: Ц.Одбат

Ишлэл: Б. Батжаргал, Н. Энхтуяа, Д. Тунгалаг, 2020. Монголын
боловсролын тогтолцоон дахь шударга бус байдлын илрэлүүд
ба эцэг эхээс авч буй төлбөр, хураамж

Энэхүү судалгааг Нээлттэй Нийгэм Сангийн Боловсролыг
дэмжих хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Боловсролын Бодлогын
Төвүүдийн Сүлжээ ба Хавсарга Бодлого ба Шударга Байдлын
Төвийн “Боловсролын тогтолцоон дахь шударга байдал”
хамтарсан төслийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.



ГАРЧИГ

ОРШИЛ	4
Судалгааны арга зүй	5
Тайлангийн тухай	6

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УЛС ОРНЫ БОЛОН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Боловсролын тогтолцоо ба шинэчлэлийн тэргүүлэх чиглэлүүд	7
Шударга байдал тогтоох ба авлигын эсрэг үйл ажиллагаа	8

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХУВИАРАА ҮЗҮҮЛЖ БҮЙ ЗҮЙ БУС НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД

Өдөр өнжүүлэх бүлэг ажиллуулах замаар нэмэлт давтлага өгөх	10
Сонгон суралцах хичээллүүлэх, гүнзгийрүүлсэн сургалт эрхлэх замаар нэмэлт давтлага өгөх	11
Зөрчил гарах боломжийг үүсгэж байгаа эмзэг байдал	13
Зөрчил гаргахад өдөөж буй, үл итгэх байдлыг үүсгэж байгаа эмзэг байдал.....	15

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЭЦЭГ ЭХИЙН ТӨЛБӨР, ХУРААМЖИЙГ ШАМШИГДУУЛАХ

Эцэг эхийн төлбөр хураамж: хэлбэр, зорилго ба хууль бус зарцуулалт	17
Хүүхэд ба эцэг эхэд ямар нөлөө үзүүлж байна вэ?	18
Зөрчил гарах боломжийг үүсгэж байгаа эмзэг байдал	18
Зөрчил гарахад өдөөж буй, үл итгэх байдлыг үүсгэж байгаа эмзэг байдал	19

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

ОРШИЛ

Энэхүү судалгааг Нээлттэй Нийгэм Сангийн Боловсролыг дэмжих хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Боловсролын бодлогын төвүүдийн сүлжээ ба Хавсарга бодлого ба шударга байдлын төвийн “Боловсролын тогтолцооны шударга байдал: Иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан сургалт” хамтарсан төслийн хүрээнд хийж гүйцэтгэлээ. Төслийн зүгээс Боловсролын бодлогын төвүүдийн сүлжээний гишүүд болох Гүрж, Киргиз, Молдова, Монгол улсуудын иргэний нийгмийн байгууллагуудад боловсрол дахь шударга байдлыг хэрхэн үнэлэх талаар сургалтыг явуулсны үндсэн дээр шударга байдлыг хэд хэдэн чиглэлээр үндэсний түвшинд судалж, энэ 4 оронд хийгдэх боловсролын шинэчлэлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлохыг зорьсон.

Энэхүү судалгааны арга зүйг Хавсарга бодлого ба шударга байдлын төвөөс Эдийн засаг, хөгжлийн хамтын ажиллагааны байгууллага (ЭЗХХАБ)-ын бодлогын хүрээнд боловсруулж, 2010 оноос хойш боловсролын тогтолцооны шударга байдлыг үнэлэх, судлахад ашиглаж ирсэн аргачлал юм.

Энэхүү үнэлгээний зорилго нь боловсролын тогтолцоонд амь бөхтэй зууралдаж байгаа авлигын нөхцөл, шалтгааныг бодлоготой холбон ойлгоход үндэсний түвшний шийдвэр гаргагчид ба оролцогч талуудад туслах, улмаар гарч байгаа бодлогын алдаа дутагдлыг үндэс сууриар нь арилгах, урьдчилан сэргийлэх, нөхцөл байдлыг сайжруулах шийдлүүд боловсруулахад нь дэмжлэг үзүүлэхэд оршино. Шударга бус байдлын илрэлүүд, боловсрол дахь авлига нь салбарт гаднаас нөлөөлж байгаа үзэгдэл биш, боловсролын тогтолцоонд өөрт нь гүнзгий шигдсэн асуудлуудын үр дагавар бөгөөд салбарын шийдвэр гаргагч, хэрэгжүүлэгч, оролцогч талуудын хүчин чармайлтаар шийдвэрлэгдэж болох асуудал гэсэн хандлагыг баримталж үнэлгээг хийсэн (ЭЗХХАБ, 2018).

Энэхүү арга зүй нь оролцогчид авлигын үйлдэлд гар бие оролцсон эсэх, хэрэв тийм бол нөхцөл байдал хэрхэн нөлөөлсөн бэ гэсэн хоёр асуултад хариу өгөхийг хичээнэ (Милованович, 2020). Боловсролд оролцогч талуудын хувьд ямар бодлого, өдөр тутмын үйл ажиллагаа нь авлигын үйлдэлд оролцох боломж олгодог эсхүл өдөөдөг вэ гэдэгт гол анхаарлаа хандуулна.

Энэхүү тайланд гарах “авлигын үйлдэл” гэсэн хүрээнд эрүүгийн хэрэгт тооцогдох үйлдлүүд, мөн түүнчлэн илүү зөөлөн буюу салбарын онцлогтой, хор хохиролтой боловч Олон улсын стандартаар авлига гэж тооцогдохгүй үйл ажиллагааг багтаана. “Шударга бус үйлдлүүд” гэдэгт дээрх хоёр төрлийн үйлдэл багтах бөгөөд мэргэжлийн албан тушаал дээр байгаа боловсролд оролцогч талуудын зүгээс (боловсролын захиргааны ажилтнууд, захирал, багш нар) зорилготой, системтэй хийх үйлдэл ба тэдгээр нь тухайн үнэлгээ

хийлгэгдэж байгаа улс орны боловсролын тогтолцоонд баримталдаг үнэт зүйл, зарчмыг зөрчсөн байхыг ойлгоно (ЭЗХХАБ, 2018). Энэхүү тайланд системийн хүрээнд явагддаг шударга бус үйлдлийн ангиллын 2019 онд шинэчлэн сайжруулсан хувилбарыг баримталсан /Хүснэгт 1/

1	Боловсролын хүртээмжийг хууль бус замаар хангах	Боловсролын хүртээмжээр хангахад оролцдог эрх мэдэл бүхий хүмүүс энэ байдлаа ашиглан дур мэдэн шимтгэл, төлбөр бий болгох, зохисгүй байдлаар давуу тал олж авах, эсвэл хэтдээ ашиг харах замаар хүртээмжид саад болох эсвэл бий болгох
2	Зүй бусаар хувиараа нэмэлт давтлага, сургалт зохион байгуулах	Багш нар хувийн ашиг тусын тулд өөрийн зааж үнэлгээ өгдөг хичээлээрээ өөрийн сурагчдадаа ердийн сургалтаас гадуур хичээл, сургалтын үйл ажиллагаа явуулж сурагчдын үнэлгээ дүнг ахиулах
3	Боловсролыг улс төрийн зорилгоор ашиглах	Хувийн болон улс төрийн давуу байдал олж авахын тулд (нийтийн) боловсролд улс төрийн холбоо, итгэл үнэмшил, сүлжээг бий болгох, дэмжих, сурталчлах
4	Сурлагын амжилтыг буруу үнэлэх	Хувийн ашиг хүртэх эсвэл түүнээс хэтдээ ашиг харж, жирийн сургуулийн сурагчдын дүнг зориудаар ахиулан эсвэл дутуу үнэлэх, төгсөлтийн гэрчилгээг хуурамчаар олгох
5	Хүний нөөцийн шийдвэрийг танил талд ашигтайгаар гаргах	Шийдвэр гаргах эрх бүхий этгээд нь найз нөхөд, хамт ажиллагсад эсвэл ойрын харилцаатай хүнд хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажил хөдөлмөр эрхлэлттэй холбоотой албан тушаал, зэрэг цол дэвшүүлэх, тэтгэмж олгох зэрэг ашиг хүртэх хэлбэрээр нийтийн төсвийн нөөцийг хуваарилах
6	Боловсролд зориулсан хөрөнгийг шамшигдуулах	Эзэмших эрхгүй ч удирдлагаас итгэмжлэгдсэн байдлаа ашиглаж боловсрол дахь хөрөнгө, сангаас завших, хулгайлах
7	Худалдан авах ажиллагааны луйвар	Боловсролын үйлчилгээ үзүүлэгчдэд бараа, ажил үйлчилгээг нийлүүлэхдээ хувийн ашиг хонжоо харж, хууль бус/луйврын арга ашиглах
8	Мэхлэх	Сурлагын дүн хийсэн ажил болон эсвэл олж авсан мэдлэг чадвараа хуурамч аргаар (үүнд хүний зохиол бүтээлээс хулгайлах багтана) дүгнүүлж албан ёсны болгох
9	Магадлан итгэмжлэл, лицензийн луйвар	Хувьдаа давуу байдал олж авах, эсвэл хэтийн ашиг харах зэрэг хуурамч арга ашиглан үйл ажиллагаа эрхлэх, зэрэг олгох зөвшөөрөл/эрх авах эсвэл хөтөлбөрийн магадлан итгэмжлэл авах

Эх сурвалж: (ЭЗХХАБ, 2018)

Дээрх арга зүйн дагуу судалгааны хүрээнд шударга бус үйлдлүүд гарах орчин нөхцөлийг үүсгэж байгаа боловсролын эмзэг асуудлуудын талаар нотолгоо цуглуулж, шийдвэр гарагчид болон хэрэгжүүлэгчдэд мэдээлэл өгснөөр нөхцөл байдлыг сайжруулах, өөрчлөхөд нь дэмжлэг үзүүлнэ. "Эмзэг асуудал" гэдэг нь багш, захирал, эцэг эх, боловсролын захиргааны ажилтнууд зэрэг боловсролд оролцогч талууд шударга бус үйлдэл хийх боломж, уг үйлдэлд оролцох болдог учир шалтгаан, түүнд хүргэдэг боловсролын бодлого ба практик үйл ажиллагаануудын сул тал, хийдлүүд юм (Ковакс-Церович. Т. нар, 2019).

Судалгааны арга зүй

Энэхүү тайлан нь эцэг эхийн зүгээс төлж байгаа төлбөр, хураамжуудыг тогтоож, түүний Монгол Улсын боловсролын салбар дахь шударга байдалд үзүүлэх нөлөөг судалсан. Ялангуяа эцэг эхийн зүгээс төлж байгаа төлбөр, хураамжууд зэрэг бага, дунд боловсролын түвшинд гарч байгаа зөрчлүүд, түүнд хүргэж байгаа эмзэг байдлыг үнэлэхэд голлон анхаарсан. Монгол Улсын боловсролын тогтолцоонд байгаа шударга бус зөрчлүүдийн талаар мэдлэг ойлголттой болох, системтэйгээр тодорхойлох анхны цогц оролдлогыг хийснээрээ энэ судалгаа онцлогтой юм.

Энэхүү үнэлгээнд зориулан мэдээлэл цуглуулахдаа фокус бүлгийн ярилцлага, ганцаарчилсан ярилцлага, нийгмийн сүлжээний мэдээллийн дүн шинжилгээ, баримт бичгийн судалгаа зэрэг аргуудыг хэрэглэв. Фокус бүлгийн ярилцлагаар нотолгоо цуглуулахдаа ИНТЕС-т суурилсан АЙРЕН арга зүйг (Ковакс-Церович. Т. нар 2019) хэрэглэсэн ба түүх ярих арга зүйг голлон ашигласан (Даикют, Ц. Ковакс-Церович. Т. нар, 2017). Энэ нь багш, эцэг эх, иргэний нийгэм ба эрх мэдэлтнүүд зэрэг боловсрол дахь авлигын үйлдэлд оролцдог талуудаар өөрсдийнх нь туршлагыг яриулах замаар нөхцөл байдлыг илүүтэй ойлгох зорилготой мэдээлэл цуглуулах арга юм.

Энэхүү судалгааны хүрээнд олон төрлийн сургууль дээр эцэг эхчүүдээс авч байгаа төлбөр, хураамжийн нөхцөл байдлыг судалж мэдэхээр түүх ярих арга зүйг хэрэглэн 3 удаагийн фокус бүлгийн ярилцлагыг зохион байгууллаа. Эхний ярилцлагыг жил тутмынхаа чуулганд оролцож байсан Сургуулийн эцэг эх-багшийн холбооны гишүүдийн дунд зохион байгуулсан бөгөөд 4 аймгийн 6 сумын сургуулийн 23 эцэг эх оролцсон. Түүх ярих арга зүйг хэрэгжүүлэхдээ Азийн сангийн судалгааны материалыг ашиглан зохиосон эхийг хэрэглэв. Сургуульд элсэж байгаа хүүхэд, өөр сургуульд шилжиж байгаа хүүхэд, өөрийн багшийн ажиллуулдаг өдөр өнжүүлэх төвд явдаг хүүхдийн тухай 4 түүхийн эхлэл хэсгийг оролцогчдод өгч, бүлгээр ажиллан тухайн түүхийн эерэг, сайн сайхан төгсгөлийг гүйцээж бичихийг

даалгасан. Бүлэгт сургуулийн болон цэцэрлэгийн багш нар байсан нь хүндрэл үүсгэсэн. Түүхийг дуусгахдаа цөөн тохиолдолд амьдрал дээр гардаг шударга бус үйлдлүүдийг илэрхийлсэн байсан нь багш нарын зүгээс эргэлзээ, эсэргүүцлийг дагуулж, бүлгийн бусад гишүүд тэднийг дагасан байх магадлалтай. Бүлгийн ярилцлагаас эцэг эхийн төлбөр хураамж, чанартай сайн гэгддэг төрийн өмчийн сургуульд хууль бусаар хүүхдээ элсүүлэх, сурагчийн амжилтыг шударга бусаар үнэлэх ба эдгээр хууль бус үйлдлүүдээс урьдчилан сэргийлэх арга замууд зэрэг сэдвийг хөндөж ярилцсан.

Дараагийн бүлгийн ярилцлагыг Өвөрхангай аймагт 5 хүнтэй зохион байгуулсан ба тэдний 3 нь малчин, 1 нь төрийн бус байгууллагын төлөөлөл, 1 нь тэтгэвэрт гарсан сургуулийн ажилтан байсан. Өөр нэгэн фокус бүлгийн ярилцлагыг Улаанбаатар хотод 7 хүнтэй зохион байгуулахад төрийн бус өмчийн сургуульд явдаг хүүхдийн эцэг эх, олон улсын төрийн бус байгууллага, үндэсний төрийн бус байгууллагын төлөөлөл, их дээд сургуульд ажилладаг ба төрийн алба хаагч байсан хүмүүс оролцсон.

Улаанбаатар хот болон Өвөрхангай аймгийн боловсрол хариуцсан ажилтнуудтай хэд хэдэн удаагийн ганцаарчилсан ярилцлага хийсэн.

Үүний өмнө баримт бичгийн судалгааг хийж гүйцэтгэсэн бөгөөд Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Багшийн ёс зүйн дүрэм, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөр, Азийн сангаас хийсэн “Боловсролын салбарын ил тод байдал, ёс зүй, авлигын асуудал” судалгаа, АТГ-ын Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа болон бусад тандалт, судалгааны тайлан, нийгмийн сүлжээнээс авсан материалыг ашиглав.

Тайлангийн тухай

Энэ удаагийн тайланд Монгол Улсын бага, дунд боловсролын тогтолцоонд хамгийн нийтлэг тохиолддог шударга бус үйлдлийн нэг болох эцэг эхээс хураадаг төлбөр, хураамжийн (хандив) асуудлыг хөндсөн. Энэ хэлбэр нь өөрөө хуулиар хориотой төдийгүй, өөр бусад шударга бус үйлдлүүдэд хүргэдэг сөрөг үзэгдэл юм. Монголд олон төрлийн нөхцөл байдалд төрөл бүрийн хэлбэрээр энэхүү шударга бус үйлдэл нь илэрдэг. Бага ангийн сурагчдын өдөр өнжүүлэх үйлчилгээний төлбөр, зүй бусаар хувиараа зохион байгуулсан нэмэлт хичээл, давтлагын төлбөр /Хүснэгт 1/ эсвэл дараа нь шамшигдуулдаг шууд хандивын хэлбэртэй байдаг. Энэхүү тайланд энэ шударга бус үйлдлийн шалтгаан болсон бодлогын хийдлүүдийг

гаргаж ирэн, тогтолцооны сул талын дүн шинжилгээг хийж, урьдчилан сэргийлэх боломжит арга хэмжээнүүдийг санал болгосноор үндэсний түвшинд энэ асуудлаар яриа хэлэлцүүлэг хийх үүд хаалгыг нээж байна.

2012-2014 онд бусад орнуудад хийгдсэн энэ төрлийн судалгаагаар авлигын тохиолдлуудын 28 хувьд нь багш нарын оролцоо байсан байна. Иймээс энэ судалгаа нь багш нарын оролцоотойгоор шударга ёс зөрчигдөж байгаа практик үйл ажиллагаанд илүү анхаарах болно.

Энэхүү тайлан нь 4 бүлгээс бүрдэнэ. Эхний бүлэгт улс орны нөхцөл байдал, боловсролын тогтолцооны талаарх тойм мэдээлэл, боловсролын бодлогын гол тэргүүлэх чиглэлүүдийг багтаана. Хоёрдугаар бүлэгт эцэг эхээс хураадаг төлбөр, хандивтай холбоотой шударга бус үйлдлүүдийг тодорхойлж дэлгэрэнгүй тайлбар өгнө. Гуравдугаар бүлэгт шударга бус үйлдэл гарах боломж болон түүнд оролцох өдөөлт үүсгэдэг зүйлсэд учир шалтгааны дүн шинжилгээ хийнэ. Дөрөвдүгээр бүлэгт боломжит шийдлүүдийг санал болгоно.

Нэгдүгээр бүлэг. УЛС ОРНЫ БОЛОН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Өргөн уудам газар нутагт тархан суурьшсан хүн ам болон эрс тэс 4 улирлын цаг уур нь Монголд өвөрмөц сорилтуудыг бий болгодог бөгөөд 1990 оноос хойш зах зээлийн эдийн засагт шилжихээс эхлээд маш том өөрчлөлтүүдийг даван туулж ирсэн ч тэгш бус хөгжлийн болон байгаль орчны сорилтуудтай нүүр тулаад байна. Одоогоор Монголын хүн ам 3,2 сая бөгөөд дэлхийн хамгийн таруу суурьшсан улс орон гэгддэг. 2017 он гэхэд хүн амын нягтшиллын хувьд орон нутагт 1 хавтгай дөрвөлжин километр нутагт 2 хүн ногддог бол эсрэгээрээ Улаанбаатар хотод 1 хавтгай дөрвөлжин километр нутагт 314 хүн ногдож байна. Эх газрын эрс тэс уур амьсгал хүйтэн өвөл, богино зунтай нийлэн хүн амын амьжиргааны гол хэрэгсэл болсон мал аж ахуйд асар хүнд тусдаг. Хот хөдөөгийн орлогын ялгаа асар их. Тухайлбал, хотын хүний орлого нь хөдөөгийн хүний орлогоос дунджаар 24,2 дахин их байгаагаас энэхүү ялгаа тод харагдана.

Үе удам дамжсан хөдөөгийн ядуурал хүүхдээ сургуульд явуулах, сургуулийн дүрэмт хувцас, өвлийн хувцас, сурах бичиг, хичээлийн хэрэглэл, унаа, хичээлээс гадуурх үйл ажиллагаа болон хандив зэрэг сургалтын “нуугдмал” зардлыг төлөх өрх гэрийн санхүүгийн чадавхад сөргөөр нөлөөлдөг. Монголын боловсролын тогтолцоо нь хэд хэдэн сорилттой тулгарч байгаагийн нэг нь боловсролын чанарыг бүх шат түвшиндээ сайжруулах нэн яаралтай хэрэгцээ юм. Сургуульд хамрагдалт бүх түвшиндээ өндөр, тавьсан зорилтууд амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд 2018-2019 оны хичээлийн жилд бүх шатны боловсролын 2 393 байгууллагат 1 029 000 сурагч оюутан хамрагдаж байна. Боловсролын салбарт чанар, эрх тэгш байдал, засаглалын чиглэлээр санаа зовоосон асуудлууд нэмэгдсээр байгаа юм.

Боловсролын тогтолцоо ба шинэчлэлийн тэргүүлэх чиглэлүүд

Өнгөрсөн 10 жилд Монгол Улсын боловсролын тогтолцоо хэд хэдэн удаа шинэчлэгдсэн. Бага дунд боловсролын суралцах хугацаа 10-12 жил болж нэмэгдсэн бөгөөд бүх хүүхдэд үнэ төлбөргүй боловсрол олгодог. Суурь боловсролын хамран сургалт 1990 онд огцом унаж, 2000 онд эдийн засаг сэргэхтэй зэрэгцэн шилжилтийн өмнөх үеийн түвшинд очсон. Хамран сургалтын цэвэр жин бага боловсролд 95,5 хувь, дунд боловсролд 92,5 хувьтай байна.

2018-2019 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 803 сургууль үйл ажиллагаа явуулж байгаагийн 245 нь Улаанбаатар хотод, 558 нь орон

нутагт байршилтай байна. Сургуулиудын 81,7 хувь нь төрийн өмчийн, 18,3 хувь нь төрийн бус өмчийн сургууль байдаг ба нийт 600 400 хүүхэд хамрагдаж байгаагийн 6,7 хувь нь төрийн бус өмчийн сургуульд хамрагдаж байна.

Сурагчдын сурлагын амжилтын талаарх нийтэд нээлттэй мэдээллээс харахад сурагчдын гүйцэтгэлийн түвшин маш доогуур, түүнчлэн Улаанбаатар хот, аймгийн ба сумын төвийн сургуулийн чанар хоорондоо ялгаатай байгаа нь сургалтын үйл ажиллагааны чанар муу байгаатай холбоотой юм. Сурлагын чанарыг дээшлүүлэх амлалтаа биелүүлэхийн тулд Засгийн газар багш бэлтгэх тогтолцооны чанарыг сайжруулах, ээлжийн тоог бууруулах, анги дүүргэлтийг багасгах зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай болж байна.

Боловсролын төсөв ижил төстэй орнуудтай харьцуулахад дундаж төвшинд буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 4,6 хувийг боловсролын салбарт зарцуулж байна. 1998 оноос сургуулийг нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаар санхүүжүүлж эхэлсэн. Зарчмын хувьд энэ төрлийн санхүүжилтийн тогтолцоо нь хөрөнгө нөөцийг хэрэгтэй газарт нь хуваарилах, өөрөөр хэлбэл санхүүжилт сурагчаа дагаж үйлчлэх ёстой байтал сургуулийн төсвийг төлөвлөж зарцуулах эрх мэдэл сургуульд байхгүй байгаа нь сургуулийн хариуцлага, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэхэд нөлөөлж чадахгүй байна. Боловсролын хууль тогтоомжийн хэрэгжилт сул, шинэчлэл, өөрчлөлт хийх хүсэл эрмэлзэл доогуур, хариуцлага, ил тод байдал хангалтгүй, засаглалын тогтолцоо бүрэн утгаар ажиллахгүй байгаа нь боловсролын чанарыг сайжруулахад саад болсоор байна.

Шударга байдал тогтоох ба авлигын эсрэг үйл ажиллагаа

Авлига болон түүний сөрөг үр дагаварт олон нийт ихэд анхаардаг. 2018 онд хөдөөгийн сум, аймаг, нийслэлийн иргэдийг оролцуулан зохион байгуулсан Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох 19 дэх судалгаанд Монголд шийдвэрлэх ёстой гол гол асуудлыг эрэмбэлэхэд авлигын асуудал хоёрдугаар байрт жагссан байна.

2006 оноос хойш улс төрийн нам, УИХ, Засгийн газар зэрэг улс төрийн институциудын талаарх олон нийтийн үнэлгээ муудсаар ирсэн ба өнөөдөр хамгийн их авлигажсан байгууллагууд гэж тооцогдож байна. АТГ-аас 2018 онд хийсэн үндэсний хэмжээний Авлигын нөхцөл байдлын гуравдах үнэлгээгээр 2016 онд эхний таван байрыг эзэлж байсан шүүх, газрын алба, эрүүл мэнд, төрийн захиргааны байгууллагуудын нөхцөл 2018 онд өөрчлөгдөөгүй байна. Боловсролын байгууллагууд 2016 онд есдүгээрт эрэмбэлэгдэж байсан бол 2018 онд тавдугаарт эрэмбэлэгдэж, судалгаанд

оролцогчдын 41% нь энэ салбарт авлига өргөн тархсан гэж үнэлжээ (АТГ-ын цахим хуудас).

Азийн сангаас засаглал, ил тод байдлыг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд авлигын судалгааг 2006 оноос хийж эхэлсэн ба хувийн хэвшлийн байгууллагуудыг оролцуулдагаараа онцлог. Энэ судалгааны дүнгээр улс төрийн нам, газрын алба, уул уурхайн салбар хамгийн их авлигад өртсөн гэж гарсан бол боловсролын салбар нь авлигад бага өртсөн гэж гарчээ. 2012-2014 онуудын судалгаагаар авлигын үйлдлийн 28%-д нь багш нар ямар нэгэн байдлаар холбогдсон байна.

2016 оны Азийн сангийн судалгаагаар боловсролын салбар дахь авлигын хэлбэр, шалтгаан, ёс зүйн болон бусад хүчин зүйлүүд авлигад нөлөөлдөг талаар судалгаа хийжээ. Боловсролын салбарт хандив тусламж, төлбөр хураамжийн асуудал анхаарал татаж байгааг илрүүлсэн бөгөөд судалгаанд хамрагдсан эцэг эхийн 19,5% нь л ямар нэгэн төлбөр, хандив өгөөгүй гэжээ. Өөрөөр хэлбэл цэцэрлэгийн болон сургуулийн насны хүүхэдтэй 5 өрх тутмын 4 нь ямар нэгэн хэлбэрийн төлбөр, хандив өгсөн гэдгээ илэрхийлсэн байна. Тэдний 40% нь төлбөр хураамжаа хэрхэн зарцуулсан талаар эцэг эхэд эргэн тайлагнадаггүй гэжээ. Эцэг эхчүүдээс салбарын хэмжээнд хэдий хэмжээний төлбөр, хандив цуглуулж, юунд зарцуулж байгаа талаар олон нийт маш бага мэдээлэлтэй байгаа нь судалгаанаас харагдаж байна. Дийлэнх хандив, тусламжийг багш нар бэлнээр хурааж, ямар ч хяналт, тайлагналтгүй байгаа нь олон нийтийн нүдэнд ашиг сонирхлын зөрчил, авлига гэж харагдаж байна. Ихэнх тохиолдолд боловсролын салбар дахь ёс зүйгүй үйлдэл, авлигын тохиолдол нь эцэг эхчүүдийн хандлага, салбарын төсөв санхүүгийн дутагдал, багш ажилтнуудын цалин урамшуулал, ажлын нөхцөл муу байгаатай холбоотой байна. Ёс зүйгүй үйлдэл боловсролын салбарт хэвийн мэт харагдаж, судалгаанд оролцогчид зарчмын хувьд буруушааж байгаа боловч бодит байдалд эвлэрэх хандлагатай байна. Судалгаанд оролцогчид авлига болон ашиг сонирхлын зөрчлийг хэрхэн шийдвэрлэх ямар нэгэн захиргааны арга хэмжээ санал болгоогүй байсан нь сонирхол татна. Судалгаанд оролцогчдын 60% нь өнөөгийн хяналт хариуцлагын тогтолцоо нь боловсролын салбар дахь ёс зүйгүй үйлдэл, авлигыг хянахад хангалттай биш гэж үзсэн байна.

Хоёрдугаар бүлэг. ХУВИАРАА ҮЗҮҮЛЖ БҮЙ ЗҮЙ БУС НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД

Хувиараа зохион байгуулах нэмэлт давтлага, сургалт нь сурагчийн анги дэвших, төгсөхтэй холбоотойгоор аль нэг хичээлийг төлбөртэй заах явдал бөгөөд хичээл сургалтын цагаас гадуур явагддагаараа онцлогтой (Брей ба Лукин, 2012). Эдгээр нь үнэлгээ, тест, шалгалтад сайн бэлтгэх, сургалтын хөтөлбөрийн тодорхой нэг хэсгийг ойлгох, эсхүл олимпиад зэрэг академик уралдаан тэмцээнүүдэд амжилт гаргах зорилготой байдаг.

Нэмэлт давтлага, сургалт нь үнэ төлбөргүй, хичээлийг нэмж баяжуулах зорилготой байх тохиолдолд хууль ёсны байж болох ба байх ч ёстой зүйлийн нэг болно. Гэвч хувийн нэмэлт давтлагын зарим хэлбэр нь давтлага өгч байгаа хүний хувьд шударга бус үйлдэл болж хариуцлага хүлээх болох бөгөөд тухайлбал давтлага өгч байгаа хүн нь өөрийн сургуулийн багш, өөрөөр хэлбэл өөрийнхөө сургуулийн сурагчдад хувиараа төлбөртэй явуулж байгаа тохиолдол үүнд багтана (Брэй 2009; ЭЗХХАБ 2018). Энэ нь ашиг сонирхлын зөрчил үүсгэж болох ба шалгалтад тэнцүүлэх нөхцөлөөр нэмэлт үйлчилгээ үзүүлэхэд багш нар оролцож байгаа тохиолдолд тухайн багшийн хувьд хууль бус үйлдэл, шударга бус үйлдэл болно.

Энэ хэлбэрийн нэмэлт давтлагыг судалгааны хүрээнд “хувиараа үзүүлж байгаа зүй бус нэмэлт үйлчилгээ” гэж ангилж байгаа бөгөөд өөрсдийн тогтмол хийж байгаа боловсролын салбарын ажил дээр нэмээд хувьдаа ашиг олох зорилгоор өөрийн сурагчид өөрийн заадаг хичээлээр дэмжлэг үзүүлэх эсхүл амжилтыг нь ахиулах зорилгоор хувиараа давтлага өгөх нь шударга бус үйлдэл гэж тодорхойлж байна (Хүснэгт 1).

Энэ бүлэгт хувиараа зүй бус нэмэлт давтлага, хичээл заах үйлчилгээний хоёр хэлбэрийг авч үзнэ. Эхнийх нь багш өөрийн сурагчдаа зориулж өдөр өнжүүлэх бүлгийг төлбөртэй ажиллуулах, нөгөө хэлбэр нь багш гүнзгий, сонгон, тусгай ангийг хичээлийн дараа болон сургуулийн амралтаар төлбөртэй хичээллүүлэх хэлбэр болно.

Өдөр өнжүүлэх бүлэг ажиллуулах замаар нэмэлт давтлага өгөх

Боловсролын тухай хуульд (18.1 дүгээр зүйл) зааснаар сургуулиас гадуурх сургалтын ажил эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллага, иргэн өөрийн үйл ажиллагааны чиглэлээр тодорхой хүрээний асуудлаар тусгай хөтөлбөрийн дагуу хүүхэд, насанд хүрэгчдэд боловсрол эзэмшүүлэх, боловсрол мэргэжлээ дээшлүүлэхэд нь туслалцаа, өдөр өнжүүлэх үйлчилгээ үзүүлж болохоор заажээ. Өдөр өнжүүлэх үйлчилгээ гэж эцэг эх, асран

хамгаалагчийн хүсэлтийн дагуу сургалтын байгууллага иргэнтэй харилцан тохиролцож үйлдсэн гэрээний үндсэн дээр эрүүл, аюулгүй орчинд хүүхдийг асран хамгаалах, хөгжлийг дэмжих, сургалтаас гадуур үзүүлэх үйлчилгээг хэлнэ гэж дээрх хуульд мөн тодорхойлсон байна.

Бага ангийн сурагчдын хувьд дээрх үйлчилгээний хэлбэрээр нэмэлт давтлага авахад эцэг эхчүүд нь мөнгө зарцуулж байна. Хэдийгээр энэ нь завгүй эцэг эхчүүдийн эрэлт хэрэгцээг хангаж байгаа ч энэхүү үйлчилгээг нэмэлт орлого олох эх үүсвэр болгож байгаа багш нарын хандлага гол асуудал болж байна. Асуудал нь багш нар энэхүү үйлчилгээг өөрийн ангийн сурагчдад өөрийн заадаг хичээлээр үзүүлдэгт оршино. Багш эцэг эхчүүдэд хүүхдийн чинь сурлага муу байна гэж хэлээд өдөр өнжүүлэх үйлчилгээнд хамрагдаж нэмэлт давтлага авахыг зөвлөх эсхүл эелдгээр шахаж шаарддаг байна.

Өдөр өнжүүлэх бүлгийн багш нарын 75% нь хүүхдийнх нь одоо хичээл заадаг багш буюу өмнө нь хичээл зааж байсан багш байна. Багш нарын дийлэнх нь бага боловсролын, сургуулийн өмнөх боловсролын, эсвэл монгол хэлний багш мэргэжилтэй байна. Цөөнгүй тохиолдолд тухайн сургуулийн багш өдөр өнжүүлэх бүлэг хичээллүүлж, давхар хөдөлмөр эрхэлж байгаа гэсэн үг. Багш үндсэн ажлаасаа гадуур давхар ажил эрхэлж, өдөр өнжүүлэх үйлчилгээг албан ёсны зөвшөөрөлгүй явуулж, өөрийн хичээл заадаг сурагчдыг хамруулан төлбөр авч байгаа нь “хэдийгээр зарим эцэг эхчүүд хүсэж байгаа ч гэсэн” өөрийнх нь өдөр өнжүүлэх бүлэгт явдаг сурагчид давуу тал олгож, олсон орлогоо тайлагнахгүй, татвар төлөхгүй байгаа нь хэд хэдэн хууль тухайлбал, Боловсролын тухай, Хүүхдийн эрхийн тухай Зөрчлийн тухай хууль болон Багшийн ёс зүйн дүрэм, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг зөрчиж байна.

Хуулийн дагуу ангийн багш өөрийн сурагчид төлбөртэй давтлага, дамжаа явуулах ёсгүй. Гэвч энэ нь нууц хэлбэрт шилжиж өөрийн хувийн харилцаа холбоо, танил тал, найз нөхдийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсаар байна. Олонх тохиолдолд тэтгэвэрт гарсан эсхүл өөр багшийн зохион байгуулж буй өдөр өнжүүлэх үйлчилгээнд багш ангийнхаа хүүхдийг хамруулж, нэмэлт орлогоо хувааж авдаг байна. Энэхүү үйлчилгээний төлбөр нэг сард 30 000-400 000 төгрөгийн хооронд хэлбэлзэж байна.

Фокус бүлгийн ярилцлагад оролцогчдын дийлэнх нь багш хичээлийн цагаар сайн сурлагатай хүүхдүүдтэй ажиллаж, сул хүүхдүүдээ орхидог бөгөөд эцэг эхчүүдийг хүүхдээ өөрийнхөө өдөр өнжүүлэх бүлэгт хүүхдээ явуулахыг “эелдгээр” хүчилдэг гэж ярьжээ.

Манай хүүхдийн багш хоёр өрөө байр түрээслэн ангийн хүүхдүүдэд өдөр өнжүүлэх бүлэг хичээллүүлдэг. Төлбөр нь сард 250 000 төгрөг. Үйлчилгээний чанар хангалтгүй ялангуяа хүүхдэд өгч буй хоол нь тааруухан. Хүүхдийн маань сурлага олигтой ахихгүй байсан тул би хүүхдээ өгөхөө болимоор байгаа ч багш нь хүүхдэд маань муугаар хандах вий гэж айгаад чадахгүй байна.

Ярилцлагад оролцсон эцэг эхийн төлөөлөл

Нийгмийн бодлогын хэлтсийн боловсрол хариуцсан мэргэжилтэнтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын үеэр орон нутагт ялангуяа аймгийн төв дээр залуу шинэ төгсөж ирсэн багш нарын явуулж байгаа өдөр өнжүүлэх үйлчилгээний тоо нэмэгдэж байгаа талаар эцэг эхчүүд гомдол гаргадаг тухай дурдсан бөгөөд тэдгээр багшийн мэдлэг туршлага дутуу байдаг ч дөнгөж ажилд орсон багшийн цалин доогуур байдагтай холбоотой байж магадгүй байна.

Энэ үйлчилгээ бага ангийн хүүхдийн хувьд эрэлт ихтэй байдаг ч албан ёсны хяналт шалгалтын тогтолцоо байдаггүй тул хүний нөөц хомсдох үед үйл ажиллагаагаа зогсоож, эзэмшигчдэд мөнгө хэрэгтэй болох үед үйл ажиллагаагаа дахин сэргээдэг тохиолдол ч байна. Хүүхдүүдийн 80% нь эхний жилдээ хамрагдаж байгаа бол дөрөвний гурав нь 6-8 настай буюу бага сургуулийн 1-3 ангийн хүүхэд байна. Хоёр өдөр өнжүүлэх төв тутмын нэг нь хамрагдаж байгаа хүүхдийнхээ талаар наад захын мэдээлэлгүй, эцэг эхтэй бичгээр байгуулсан гэрээгүй үйл ажиллагаа явуулж байна.

Хүүхэд болон тэдний эцэг эхэд ямар нөлөө үзүүлж байна вэ?

Багшийнхаа хувиараа зохион байгуулж байгаа давтлагад хамрагдаагүй хүүхдийг ямар нэгэн байдлаар ялгаварлах/алагчлан үзэх нөхцөл байдал үүсэж болзошгүй байна. Фокус бүлгийн ярилцлагын үеэр орлого доогуур гэр бүлийн хүүхдүүд хэдийгээр нэмэлт давтлага авах шаардлагатай ч багшийнхаа зохион байгуулж байгаа өдөр өнжүүлэх бүлгийн төлбөрийг хүчирдэггүй. Тэдгээр хүүхэд урлаг, соёл, спортын төрөл бүрийн уралдаан тэмцээнд оролцох боломжоо алддаг төдийгүй ангийнхнаа төлөөлж ямарваа нэг үүрэг гүйцэтгэх зэрэгт багшийг таньдаг хүний хүүхэд илүү их боломжийг эдэлж байгаа нь харагддаг гэжээ. Асуулт асуудаг, өөрийн үзэл бодлоо илэрхийлдэг, үүрэг хариуцлага нэхсэн сурагчдад таагүй хандлага үзүүлдэг тохиолдол цөөнгүй байна.

Миний хүүхдийн багш хичээлийн дараа ангийнхаа хүүхдүүдэд өдөр өнжүүлэх ажиллуулдаг. Манай нөхөр хүүхдүүдээ гэртээ хардаг тул хүүхдээ өдөр өнжүүлэхэд нь явуулдаггүй. Гэвч хэсэг хугацааны дараа хүүхэд маань өдөр өнжүүлэхэд явъя гэж надаас гуйж эхэлсэн. Шалтгааныг нь асуухад өдөр өнжүүлэхэд явдаг хүүхдүүдтэй багш сайхан харилцдаг мөртөө түүнтэй хатуу харьцаж доогуур дүн авсных нь төлөө нэг удаа цохисон байгаа юм.

Ярилцлагад оролцсон эцэг эхийн төлөөлөл

Багш өдрийн 8 цагаар сургууль дээр ажиллах ёстой. Тиймээс тэд өөрийнхөө өдөр өнжүүлэх бүлэгт хичээл заах, үйл ажиллагааг нь явуулах цаг хязгаарлагдмал байх тул хүүхдийг мэргэжлийн бус хүн, багшийн гэр бүлийн гишүүд, найз нөхөдтэй үлдээдэг байна. Дийлэнх өдөр өнжүүлэх төв нь агаарын чанар муу, хүүхэд тоглох, гүйх зай хомс тул гэрийнхээ даалгавар хийгээд сууж байдаг байна.

Өдөр өнжүүлэх төв нэртэй хорих газарт хүүхдээ мөнгө төлж байлгахаас өөр аргагүй байдалд ордог олон эцэг эх байгаа нь туйлын харамсалтай.

Нийгмийн сүлжээний мэдээлэл “Eagle news” 2019.09

15

Сонгон суралцах хичээллүүлэх, гүнзгийрүүлсэн сургалт эрхлэх замаар нэмэлт давтлага өгөх

Боловсролын хуульд заасны дагуу сургуулиуд тусгай, гүнзгий хөтөлбөрүүд, сонгон суралцах анги зохион байгуулж багш хамрагдах хүүхдийг нь сонгох, хичээл заах эрхтэй. Сурагчийг сонгон суралцуулах, мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалт зохион байгуулах эрхийг багшид өгч, сургалтын төлөвлөгөөнд заавал судлахаар тусгаагүй хичээлээс сонгон судлах эрхийг сурагчид олгожээ.

Үүнээс гадна сурагчид нь хэрэгтэй гэж үзвэл багш нэмэлт давтлага хичээл зааж болох хуулийн заалт байна. Өвөрхангай аймагт фокус бүлгийн ярилцлагад оролцсон эцэг эхчүүд ялангуяа сургуулийн амралтын үеэр багш нар төлбөртэй давтлага хичээллүүлж байгааг дурдсан бөгөөд нэг цагийн төлбөр нь 5000 төгрөг, нийт давтлагын төлбөр нь нэг хүүхдийн хувьд 50 000 төгрөг болж байгааг эцэг эхчүүд хэлсэн байна. Хүүхдийнхээ төлөө хүлээн зөвшөөрөхөөс аргагүй болдог хэдий ч тэд нар мөн нэмэлт материал, гарын авлага худалдаж авах болдогт сэтгэл дундуур байна. Тэдэнд энэхүү нэмэлт хичээлийн зорилго, агуулга, хэмжээ ач холбогдлын талаар тодорхой мэдээлэл өгдөггүйд эцэг эхчүүд сэтгэл дундуур байна.

Эцэг эхчүүд төлбөртэй нэмэлт хичээл, давтлагын талаар сургууль дээр ямар бодлого хэрэгждэг талаар мэдэхгүй байна. Дээр дурдсан үйл ажиллагаа нь Багшийн ёс зүйн дүрмийн шууд зөрчил бөгөөд тухайлбал байгууллагын эд хөрөнгийг хувийн хэрэгцээнд ашиглахгүй байх тухай 4.1.3-р заалт, хүүхдийн эрх, эрүүл мэндийг хохироох, амралт чөлөөт цагийг хасах замаар өөрийн ажлын амжилтыг урьтал болгохоос сэргийлэх 4.3.2-р заалтыг зөрчиж байгаа юм.

Манай 3 хүүхэд чанартай сайн гэгддэг сургуульд явдаг. Хамгийн том хүүхдээ сургуулиас зохион байгуулдаг англи хэлний тусгай ангид явуулдаг бөгөөд жилийн төлбөр нь 200 000 төгрөг, бодит байдал дээрээ энэ ангийн хичээл нь ердийн ангийнхаас агуулга, зохион байгуулалтын хувьд ямар ч ялгаагүй. Хичээлийн дараа хуваарьт хичээлийн үеэр үзсэнээ давтаж үзэх хэлбэрээр зохион байгуулдаг. Хүүхэд маань олон цагаар сургууль дээр байж ядардаг. Сургалтын чанар нь тааруу. Гэхдээ сургууль энэ талаар ямар бодлого баримталдгийг бид мэдэхгүй. Эхлээд 20 хүүхэдтэй хичээллэж эхэлсэн одоо 40 болж нэмэгдсэн. Сургалтын төлбөрийг багшийн илүү цагийн хөлсийг олгоход зарцуулдаг гэж тайлбарладаг.

Ярилцлагад оролцсон сайн гэгддэг сургуулийн сурагчийн ээж

Зарим тохиолдолд хүүхдийнх нь сурлагын амжилт төдийлөн сайн биш байхад эцэг эхчүүд хүүхдээ гүнзгийрүүлсэн ангид элсүүлэхээр шахаж, төлбөрийг нь төлж оруулдаг. Хэсэг хугацааны дараа хүүхэд нь бусад хүүхэдтэй харьцуулахад доогуур гүйцэтгэлтэй байгаагаа ойлгоод өөртөө итгэх итгэл нь буурч, улмаар нийгэм сэтгэл зүйн асуудалтай тулгардаг. Энэ тохиолдолд зарим эцэг эх хүүхдээ нэмэлт хичээлүүдэд суулгаснаар нөхцөл байдал улам дордож, хүүхэд сургуулиа орхих эсхүл эрсдэлт зан үйлд татагдан, дарамт шахалтаас үүдэлтэй стресс бүхимдалд автдаг.

Багш хичээлийн дараа нэмэлт хичээл, давтлага орох нь багшлах ажлын чанарт сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай. Зохих ёсоор амарч хичээлдээ бэлтгэхгүй байх нь чанартай багшлахад нь нөлөөлж болно. Багшийн өөрийн хичээл заадаг сурагчдаа нэмэлт хичээл давтлага орохыг зөвшөөрдөггүй тул тэтгэвэрт гарсан багш, хамтран ажиллагсдынхаа давтлага, нэмэлт хичээлд сурагчдаа явуулж төлбөрийг нь хувааж авах тохиолдол гарч байна. Багш хэвлэлийн компани эсвэл хамтран ажиллагсдынхаа боловсруулсан гарын авлага, үнэтэй сурах бичгүүдийг гүнзгийрүүлсэн ангид хэрэглэх зорилгоор худалдан авахыг эцэг эх, сурагчдаас шаардаж, борлуулалтын орлогоос

хувь хүртдэг тохиолдол ч цөөнгүй байна.

Манай хүүхэд элсэлтийн шалгалтад доогуур үнэлгээ авсан тул гүнзгий ангид элсэж орж чадаагүй. Гэвч хэсэг хугацааны дараа тэнцээгүй хүүхэд бүгд тэр ангид орсон байхыг мэдсэн. Би захирал, багш нарт мөнгө төлсөн бол хүүхдээ оруулж чадах байснаа дараа нь ойлгосон. Би анги даасан багшийг нь оруулж өгөхийг гуйсан боловч ямар ч арга байхгүй гээд халгаагаагүй.

Өвөрхангай аймаг. Ярилицлагад орсон эцэг эхийн төлөөлөл

Дээрх хоёр үйлдэл хоорондоо холбоотой. Ихэнх тохиолдолд эцэг эхчүүд хүүхдээ бага ангиас нь давтлага, нэмэлт хичээлд суулгаж, дунд ангид орохоор нь гүнзгийрүүлсэн ангид оруулах шалгалтад бэлдүүлж байдаг. Энэ нь эцэг эхчүүд давхар зардал гаргаж байгааг харуулж байна.

Зөрчил гарах боломжийг үүсгэж байгаа эмзэг байдал

Өдөр өнжүүлэх үйлчилгээ

Шударга байдлын хувьд асуудалтай байгаа ч өдөр өнжүүлэх төвүүдийн тоо өсөн нэмэгдсээр байгааг зогсоож чадахгүй байна. Өдөр өнжүүлэх төвүүд нь ямар нэгэн тусгай зөвшөөрөл, лиценз авдаггүй, үйл ажиллагаанд нь тавигдах стандарт шаардлагууд батлагдаагүй, байнгын тогтмол хяналтгүйгээр үйл ажиллагаагаа явуулсаар байна. Ямар ч хувь хүн энэ төрлийн үйлчилгээг эрхлэх нь нээлттэй байна. Өдөр өнжүүлэх төвүүдэд тавигдах стандарт, шаардлага батлагдаагүй учир албан ёсны мэргэжлийн хяналт тавих боломжгүй байна.

Өдөр өнжүүлэх төвүүдэд зөвшөөрөл олгогдохгүй байна. Бид нар эхлээд Боловсролын яам, Хүүхэд хөгжлийн газар дээр очиж уулзсан. Хэрхэн яаж зөвшөөрөл авах вэ гэдгээ олж мэдэхээр хандсан боловч ямар нэгэн эрх зүйн баримт бичиг гарсныг мэдэхгүй мэргэжлийн хяналтын байгууллагад ханд, танай ариун цэврийн нөхцөл байдлыг хянаж дүгнэлт гаргана гэж хэлсэн.

Өдөр өнжүүлэх төвийн менежер

Хуульд заасан эцэг эхчүүдтэй гэрээ байгуулах заалт огт хэрэгжихгүй, ихэнх төв хүүхдийн эцэг эхтэй ямар ч гэрээ байгуулахгүй ажиллаж байна.

Гэрээний талаарх болон харилцан хариуцлага хүлээх тухай эцэг эхийн ойлголт хангалтгүй байна. Хоёр талын хувьд төлбөр төлсөн байх нь хамгийн чухал байгаа тул өдөр өнжүүлэх төвд байгаа хүүхдийн хөгжил, хамгааллын асуудал хоёрдугаарт тавигдсаар байна. Эрүүл мэндийн яам, Боловсролын яамны хамтарсан 2018 оны 02-р сарын тушаалаар батлагдсан Хүүхэд хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2018, 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд стандарт батлан мөрдүүлэхээр тусгасан ч хэрэгжээгүй байна. Өдөр өнжүүлэх төвийн чанарыг баталгаажуулах механизм хангалтгүй байгаа тул үйлчлүүлэгчдийн гомдол гарсаар байна.

Өдөр өнжүүлэх төв аль яаманд харьяалагдах нь тодорхойгүй, үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл хэн олгох нь ойлгомжгүй, албан ёсны бүртгэлийн тогтолцоогүй, нэр хаяг нь ч стандарт шаардлагагүй байгаа тул мэдээлэл цуглуулах, олж авахад хүндрэлтэй байна. Энэ судалгаанд Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2018 онд хийсэн судалгааны дүнг ашиглав.

Сонгон суралцах ангиуд

18

Сургуулиудад тусгай болон гүнзгийрүүлсэн анги/хөтөлбөрүүдийг сурагчдад зориулан төлбөртэй зохион байгуулахыг зөвшөөрсөн. Энэ нь сургуулиудын нэмэлт орлого олох сонирхлыг өдөөж тооны хойноос хөөцөлдсөнөөр чанар орхигдож, сургалтын үйд ажиллагаанд эцэг эхчүүдийн сэтгэл ханамж доогуур байна.

Ерөнхийдөө оролцогч талуудад ёс зүйн дүрмийн талаар цогц мэдлэг ойлголт дутуу, багш нар тусгай, сонгон судлах хичээл болон нэмэлт хичээл давтлагыг хичээлийн дараа болон сургуулийн амралтаар зохион байгуулж оролцоход сургуулийн зүгээс тавих хяналт, төлбөрийн тогтолцоо маш тодорхойгүй байна.

Сургалтын нэмэгдэл зардлын хэмжээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан жишгийг үндэслэн сургуулийн зөвлөл эцэслэн тогтоох үүрэгтэй байдаг. Гэвч бодит байдал дээр Боловсролын яам ямар нэгэн хэм хэмжээний акт гаргаагүй ба сургуулийн зөвлөлүүд ч олон жил үйл ажиллагаагаа явуулахгүй зогсонги байдалд байна.

Боловсролын яамнаас баталсан гүнзгийрүүлсэн сургалт явуулах журамд сурагчийн төлбөрийн 30 хүртэлх хувьтай тэнцэх нэмэлт цалинг гүнзгийрүүлсэн сургалт хариуцан явуулсан багш авахаар зохицуулсан байдаг. Сурагчийн төлбөрийн үлдэгдэл нь сургалтын анги, танхим сургалтын материал, гарын авлага, багшийн хэрэглэгдэхүүнд зарцуулагдах

ёстой. Боловсролын мэргэжлийн хяналтын байгууллагаас эдгээр сургалтын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй боловч хяналт-шинжилгээ хийх аргачлал нь үр дүнгүй байна. Аймаг, нийслэлийн боловсролын газар нь хөтөлбөр, сургалтын төлөвлөгөөг баталж, багшлах боловсон хүчин, сурах бичиг, сургалтын материал, сургалтын хэрэглэгдэхүүн, орчинд тавигдах шаардлагын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх үүрэгтэй ч ажилтнуудын тоо хязгаарлагдмал байдгаас хяналт шалгалтыг зохих ёсоор хийж чадахгүй байна. Бие биеэсээ алслагдмал орших сумын сургуулиудад биеэр очиж хяналт шалгалт хийх төсөв хүрэлцээтэй биш байдаг.

Аймгийн захиргаанд багш ялангуяа бага ангийн багшаас хичээлийн дараа болон сургуулийн амралтаар зохион байгуулж байгаа давтлага, нэмэлт хичээлийн талаарх гомдол ихээр ирж байна. Тэдгээр сургалтын чанар муу байгаа, шинэ төгссөн багш нар ажиллуулж байгаа зэрэг гомдлуудыг эцэг эхчүүд ирүүлсэн. Аймгийн түвшинд эдгээрийг хэрхэн зохицуулах, хэрхэн хяналт тавих, хэнээр заалгаж болох вэ гэдгийг зохицуулах чиглэлээр яриа хэлэлцүүлэг өрнүүлж эхлээд байна.

Нийгмийн бодлогын хэлтсийн боловсролын мэргэжилтэн

Сургуулийн амралтын үеэр болон хичээлийн дараа нэмэлт хичээл, давтлага өгөхтэй холбоотой ямар нэг дүрэм журам одоогоор байхгүй байна. Нэмэлт хичээл, давтлагын эрэлт их байдаг нь малчдын хүүхэд цэцэрлэгт хамрагдах боломжгүй байдаг болон тэд сургуульд ороод 24 цаг дотуур байранд байрладагтай холбоотой бөгөөд тэдгээр хүүхдийн эцэг эх хүүхдэдээ давтлага авахыг хүсдэг. Мөн малчдын хүүхэд амьдардаг дотуур байранд хичээл, даалгаврыг хийхэд туслах багш ганцхан байдагтай холбоотой байж болох юм. Хот суурин газарт бага ангийн анги дүүргэлт хэтэрч, 40-60 хүүхэдтэй хичээллэх үед үед зарим хүүхэд сурлагаар хоцорч, нэмэлт давтлага авахаас өөр аргагүй байдаг.

Багш нарын үзэж байгаагаар сурагчдын сурлагын амжилтыг ахиулах нь багшийн ажлын үнэлгээнд томоохон байр суурийг эзэлдэг тул тэд нэмэлт хичээл, давтлага өгөхөөс аргагүй байдалд хүрдэг. Багшийн ажлын үр дүнг сургалтын менежер, сургуулийн захирлын нэрийн өмнөөс үнэлж оноо тавьдаг ба улирлын үр дүнгийн урамшуулал гэж үндсэн цалингийн 45 хүртэлх хувьтай тэнцэх нэмэлт цалинг багш нар авдаг. Тиймээс хичээллэх газар, цаг зав байвал давтлага, нэмэлт хичээл хийх сонирхол багш нарт ихээр байдаг.

Эцэг эхчүүд гомдол гаргах зохих механизм байхгүй тул эцэг эхчүүдийн

гаргасан гомдол, санал шийдвэрлэгдэхгүй төдийгүй эцэг эхчүүдэд зохих ёсоор хариу өгдөггүй. Боловсролын газрын мэргэжилтнүүд сургуулийн захиралд анхааруулга өгч, гарсан асуудлыг зохицуулах чиглэл өгдөг бөгөөд сургууль дээр очих үедээ хяналт, шалгалт хийж зөвлөмж хүргүүлдэг байна. Багшийн ёс зүйн дүрмийг мөрдүүлэх байдал хангалтгүй, ёс зүйн дүрмийн зөрчлийг шалган тогтоон гарсан тохиолдолд шийтгэл хүлээлгэхгүй байна.

ЗӨРЧИЛ ГАРГАХАД ӨДӨӨЖ БУЙ, ҮЛ ИТГЭХ БАЙДЛЫГ ҮҮСГЭЖ БАЙГАА ЭМЗЭГ БАЙДАЛ

Өдөр өнжүүлэх үйлчилгээ

Өдөр өнжүүлэх үйлчилгээг эцэг эхийн хүсэлтээр боловсрол сургалтын байгууллага гэрээ байгуулан үзүүлж, хүүхдийг эрүүл аюулгүй орчинд харж, хамгаалж, хөгжүүлэх зорилготой юм. Хүн ам шигүү суурьшсан Улаанбаатар хотод төрийн албан хаагчдын хувьд сургуульд хүүхдээ хүргэж өгөх, авах асуудал замын түгжрэлээс хамааран хүндрэлтэй асуудал болоод байна. Энэ шалтгааны улмаас эцэг эхчүүд гэртээ насанд хүрэгчдийн хараа хяналтгүй орхисноос хүүхдээ багшийн хяналтад өдөр өнжүүлэх төвд орхихыг илүүд үзэж байна. Эдгээр төвүүдийн гол үйл ажиллагаа нь гэрийн даалгавар хийлгэх явдал.

Эцэг эхчүүд хүүхдээ сайн сургууль, гүнзгийрүүлсэн анги эсхүл сайн багшид өгөх сонирхолтой байдаг. Ийм хүсэлтүүд хичээлийн жил эхлэхэд улам нэмэгддэг. Манай хоёр ч сургууль үндэсний 40 топ сургуулийн нэгээр шалгарсан. Нэг сургууль нь тоо, урлагийн төрөлжсөн, нөгөө нь олон жил лаборатори сургууль байсан. Энэхүү нэр хүндтэй хоёр сургуульд хүүхдээ оруулах хүсэл эрмэлзэл эцэг эхчүүдэд байдгаас тэд хүүхдээ шилж сонгож авахад хүрдэг.

Нийгмийн бодлогын боловсрол хариуцсан мэргэжилтэн

Сонгон судлах ангиуд

Бага, дунд боловсролын чанарын түвшин доогуур гэж нийгэм бүхэлдээ болон эцэг эхчүүд үздэг. Саяхны хийсэн боловсролын бодлогын судалгаа ч үүнийг баталж байгаа юм. “Боловсролын бүх шат, төвшинд сурлагын амжилт 60 хувиас доогуур байгаа ба бага дунд боловсролын түвшинд бүр ноцтой байна. Агуулга эзэмшилтийн дундаж оноо бага боловсролын төвшинд 56 хувьтай, дунд боловсролд 46 хувьтай, ахлах ангиудад 37 хувьтай байна” (Боловсролын Хүрээлэн, 2019). Нөхцөл байдал ийм байгаа учир эцэг эхчүүд хүүхдийнхээ их, дээд сургуульд элсэх боломжийг нэмэгдүүлэхийн

тулд тэдний сургалтын амжилтыг нэмэгдүүлэх зорилгоор гүнзгий ангиудад элсүүлэн суралцуулахыг эрмэлздэг.

Би нөхцөл байдалтай эвлэрсэн. Би хүүхдээ гүнзгий ангид оруулж давтлагынх нь төлбөрийг төлж байна. Миний хүүхэд ийм боломжтой тэгээд ч дуртай суралцаж байгааг их аз гэж боддог. Энэ миний хүүхдэд сайн, энд ч хэвийн зүйл болсон. Тиймээс төлбөр төлөхөд бэлэн байгаа.

Ярицлагад оролцсон эцэг эхийн төлөөлөл

Гуравдугаар бүлэг. ЭЦЭГ ЭХИЙН ТӨЛБӨР, ХУРААМЖИЙГ ШАМШИГДУУЛАХ

Хэн нэгний хөрөнгө санхүүг хууль бусаар санаатайгаар өөртөө зориулах болон бусад зөвшөөрөгдөөгүй зорилгоор зүй бусаар зарцуулахыг шамшигдуулалт гэж ойлгоно. Ялангуяа төрийн албан хаагч, энэ тохиолдолд сургуулийн захирал ба багшийн үйлдлийг хамааруулж үзнэ. Энэ бол хөрөнгө мөнгө хулгайлсан гэж үг биш бөгөөд эцэг эхээс өгсөн хандив, төлбөрийг сургуулийн хүртээмжийг баталгаажуулах, нэмэлт сургалт хичээлд хамруулах зэрэг зорилгоор хураан авч ашиглах, тухайн мөнгийг зориулалтын бусаар зарцуулах нөхцөлийг авч үзнэ. Тухайн хөрөнгө санхүүг төрийн байгууллага дотроо зүй бусаар зарцуулсан нөхцөлийг бас багтаана.

Азийн сангаас 2016 онд хийсэн “Монголын боловсролын салбар дахь ил тод байдал, авлигын асуудлууд” судалгааны 14 асуулт нь бага дунд боловсролын салбар дахь ёс зүйгүй үйлдэл, авлигын талаар байсан. Судалгаанд оролцогчид эцэг эхчүүд хүүхдээ сургуульд хамруулах (70%), ангийг нь солих (62%), дүн засуулах (61%), тэтгэлэг авах (47%) зорилгоор авлига өгч, албан тушаалын байдал, хэлхээ холбоогоо ашигладаг гэж хариулжээ.

Багш шууд бэлэн мөнгө хураадаг нөхцөл байдал өөрчлөгдөж, ангийн эцэг эхийн зөвлөлөөр дамжуулах болсон тухай фокус бүлгийн ярилцлагад оролцогчид дахин давтан хэлж байв. Хэдийгээр мөнгө хураах нь эцэг эхийн сайн дурын санаачилга, эцэг эхийн зөвлөл тэдний нэрийн өмнөөс мөнгө хурааж байгаа, багшид хамаагүй болсон мэт яригдаж байгаа ч бодит байдал дээр багшийн шууд бус оролцоо, нөлөөлөл байсаар байна. Эцэг эхийн зөвлөлийн дарга гишүүдээр багш өөрийн таньдаг хүн, ойр дотнын найз нөхдийг сонгон томилсноор тэд багшийн талд үйлчлэх нөхцөл байдал үүсэж байгаа юм.

Сургууль төгсөлт, баяр тэмдэглэх, сургуульдаа бэлэг өгөх, багшаа баярлуулах нэрийдлээр эцэг эхчүүдээс мөнгө хураасаар байна. Өнөөдөр энэ үйлдлийг тодорхой хэмжээгээр хязгаарлаж байгаа боловч эцэг эхийн зөвлөл төрөл бүрийн аргаар мөнгө хураах ажлыг гүйцэтгэсээр байна. Эцэг эхчүүдийн эсэргүүцэл ямар ч үр дүнд хүрэхгүй байна.

Хүүхдийг нь сайн сургасны төлөө багшид талархлаа илэрхийлж бэлэг өгөхийг ойлгож хүлээн зөвшөөрч болох ч энэ үйлдлийн нуугдмал шинж чанарыг ялгаж салгахад хэцүү байх болно.

Эцэг эхчүүдээс гардаг өөр нэг төлбөр хураамж бол туслах багшийн

цалинг төлөх явдал юм. Саяхнаас бага анги туслах багштай байж болох хуулийн заалт үйлчилж эхэлсэн ба нэг багшид ногдох сурагчийн тоо өндөр, өөрөөр хэлбэл анги дүүргэлт хэтэрсэн тохиолдолд сургуулиуд туслах багш ажиллуулах болсон. Туслах багшаар МУБИС-ийн төгсөх ангийн оюутнууд ажиллаж, цалинг нь эцэг эхчүүд дундаасаа төлж байгаа практик ажиглагдаж байна. Нэг эцэг эх сард 10 000 төгрөг хураалгадаг боловч хэд нь багшид цалин болж очдогийг мэддэггүй.

Эцэг эхчүүд багшийн санал болгосон ном, гарын авлагыг худалдаж авах шахалтад байнга ордог. Энэ нь сүлжээ маягаар ажиллаж, багш ном, гарын авлага зарсныхаа төлөө хувь авдаг тогтолцоо үйлчилж байна. Ялангуяа орон нутгийн багш нарын хувьд ямар нэгэн төвийн эсхүл хотын багш нарын боловсруулсан хэдхэн хуудастай гарын авлагыг худалдаж авах дарамтад ордог. Тэдгээр гарын авлагууд нь ихэнхдээ шалгалтад бэлтгэх агуулга, зорилготой байдаг.

Эцэг эхийн төлбөр хураамж: хэлбэр, зорилго ба хууль бус зарцуулалт

Хэдийгээр Үндсэн хуулиар ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгохыг баталгаажуулсан ч эцэг эхчүүд хүүхдийнхээ боловсрол сургалтад зориулан тодорхой хэмжээний албан бус төлбөр төлсөөр байна. Хүүхдийнхээ багш, сургуульд эцэг эхээс төлдөг албан бус төлбөрийн зорилго, хэлбэрийг доорх жагсаалтаас харж болно. Бүх фокус бүлгийн ярилцлага, бичиг баримт, нийгмийн сүлжээнд хамгийн их дурдагдсан хэлбэрүүдийг давтамжаар нь жагсаалаа.

1. Баяр тэмдэглэх (Төгсөлт, шинэ жил, багш нарын баяр гэх мэт)
2. Аялал зугаалга
3. Урлагийн үзлэг, тоглолт (хувцас хэрэглэл, чимэглэл худалдан авах гэх мэт)
4. Анги засвар, тавилга худалдан авах
5. Ангийн хуримтлал
6. Бичиг хэргийн хэрэгсэл
7. Багшид принтер худалдаж авч өгөх
8. Анги цэвэрлэгээний мөнгө (зарим сургуулийн бага ангиудад)
9. Бага боловсролын туслах багшийн цалинг төлөх
10. Тусгай, гүнзгийрүүлсэн, сонгон суралцах хичээлийн төлбөр
11. Анги солих, сургуульд элсэх
12. Шалгалтын үеэр багшид хоол авч өгөх
13. Давтлага, нэмэлт хичээл
14. Багшийн боловсруулсан ном, гарын авлагыг худалдаж авах
15. Багшдаа мөнгө зээлэх

Давтагдах байдлаар эрэмбэлж үзэхэд нэмэлт хичээл, давтлага, эцэг эхээс авах төлбөр хураамж, хууль бус элсэлт эхний гуравт жагсаж хамгийн ноцтой асуудлаар гарч ирж байна. Эдгээр нь ёс зүйгүй, хууль бус байдлаар олон хэлбэрээр үйлдэгдэж, зарим тохиолдолд багшийн зүгээс хүчлэх, тулгах, шахалт үзүүлэх замаар үйлдэгддэг ба ангийн багш оролцож, эцэг эхэд буцаан тайлагнадаггүй байна.

№	Эцэг эхээс төлбөр авах шалтгаан	Давтамж
1	Анги солих, сургуульд элсэх	15
2	Давтлага, нэмэлт хичээл	12
3	Тусгай, гүнзгийрүүлсэн, сонгон суралцах хичээлийн төлбөр	12
4	Анги засвар, тавилга худалдан авах	8
5	Ангийн хуримтлал	8
6	Багшийн боловсруулсан ном, гарын авлагыг худалдаж авах	8
7	Бичиг хэргийн хэрэгсэл	6
8	Багшид принтер худалдаж авч өгөх	4
9	Анги цэвэрлэгээний мөнгө (зарим сургуулийн бага ангиудад)	4
10	Бага боловсролын туслах багшийн цалинг төлөх	3
11	Урлагийн үзлэг, тоглолт (хувцас хэрэглэл, чимэглэл худалдан авах гэх мэт)	3
12	Шалгалтын үеэр багш нарт хоол авч өгөх	1
13	Аялал зугаалга	1
14	Багшдаа мөнгө зээлэх	1
15	Баяр тэмдэглэх (Төгсөлт, шинэ жил, багш нарын баяр гэх мэт)	1

Эцэг эхийн зүгээс төлж байгаа 15 хэлбэрийн төлбөр хураамжийн 10 нь зүй бус зарцуулалттай бөгөөд хэзээ ч буцаж тайлагнадаггүй гэж фокус бүлгийн ярилцлагад оролцогчид хэлсэн байна.

Эцэг эхэд тайлагнана гэж байхгүй. Өнгөрсөн хавар манай хүүхдийн анги хөшиг авна гэж эцэг эхчүүдээс 25000 төгрөг хураасан. Хэдэн сар өнгөрсөн ч хөшгөө худалдаж аваагүй. Би эцэг эхийн хурлын үеэр болон фейсбүүкээр хэд хэдэн удаа асуусан боловч багш хариу өгөөгүй.

Эцэг эхийн төлөөлөл

Шилэн дансны хуулийн дагуу эцэг эхэд тайлагнадаг цөөн хэдэн сургууль байгаа бол дийлэнх сургууль огт тайлагнадаггүй байна.

Хүүхэд ба эцэг эхэд ямар нөлөө үзүүлж байна вэ?

Хавар болгон сургуулиуд эцэг эхээс анги засвар хийх мөнгө хураадаг. Мөнгөний хэмжээ анги, сургуулиараа ялгаатай буюу жилд 10 000-150 000 төгрөг байдаг. Энэ хэмжээний мөнгө хураалгах нь өрх гэрийн эдийн засагт хүндрэл үүсгэдэг.

Энэ төрлийн төлбөр хураамж нь амьжиргааны төвшин доогуур төдийгүй зарим тохиолдолд дундаж орлоготой гэр бүлд хүндээр тусдаг ба хүүхдэд сөргөөр нөлөөлдөг. Эцэг эх нь “хандив” өгөөгүй, сургалтын материалыг нь худалдан аваагүй хүүхдийг багш ялгаварлаж, элдвээр хэлж гадуурхдаг байна. Энэ тохиолдолд эцэг эх, хүүхдэд хоёуланд нь ичгэвтэр, таагүй нөхцөл байдал үүсдэг.

Эцэг эхийн хурлын хэлэлцэх асуудал нь мөнгөний тухай л байдаг. Мөнгөө өгөөгүй эцэг эхчүүдийн нэрийг дахин дахин дуудах эсхүл фейсбүүк группт хүүхдийн маань нэрээр мөнгөө төл гэж шаардах нь бидэнд ичгэвтэр байдаг.

Эцэг эхийн төлөөлөл

Ажилгүйдэл ихтэй орон нутагт залуу эцэг эхчүүд тэтгэвэрт гарсан эцэг эхийнхээ тэтгэврээр сургуульд “хандив” өгч байна. Малчид болон ядуу өрх, тэдний хүүхдэд төлбөр хураамжийн асуудал хамгийн хүндээр тусдаг. Тэд мэдээлэлгүй, ойлголт, мэдлэг дутмаг, өөрсдийн дуу хоолойг илэрхийлж чадахгүй байгаа нь тэднийг улам эмзэг байдалд оруулж байна. Хүүхдэд нь муугаар тусах вий гэж эмээгээд сургууль, багшийн нэхсэн мөнгө, төлбөр болгоныг өгч байна.

Би зах дээр зогсож бараагаа зардаг тул байнга бэлэн мөнгөтэй харьцдаг. Манай хүүхдүүдийн багш нар надаас байнга мөнгө зээлэхийг гуйна. Татгалзвал хүүхдэд минь муу юм болж магадгүй гэж бодоод зээлдэг. Зарим үед үнэхээр зээлж чадахгүй бол тэдэнд бараа бүтээгдэхүүнээ зээлээр өгдөг.

Эцэг эхийн төлөөлөл

Зөрчил гарах боломжийг үүсгэж байгаа эмзэг байдал

БСШУС-ын сайдын 2019 оны А/508 тоот тушаалаар сургууль эцэг эхээс хандив, дэмжлэг, тусламж авч болохоор хуульчилсан. Энэ тушаалаар эцэг эх асран хамгаалагчтай байгуулах гэрээний загвар батлагдсан ба жилд нэг удаа эцэг эх, сургалтын орчны ариун цэвэр, аюулгүй байдлыг хангах үүднээс хүүхдийнхээ ангийн засвар үйлчилгээнд зориулан хандив, дэмжлэг

өгөх үүргийг оноосон заалт байгаа юм. Сургуулийн зүгээс эцэг эхээс авсан хандив, тусламжийнхаа зарцуулалтыг ил тод, нээлттэй тайлагнах үүрэг хүлээсэн. Засгийн газар энэхүү заалт нь боловсролын болон төсвийн тухай хуультай нийцсэн гэж үзэж байгаа ч хэрэгжилтийн явцад гажуудал үүсэж байгаа нь хяналт-шинжилгээ дутагдалтай байгаатай холбоотой.

Хандив нь сайн дурын байх ёстой. Тусламж дэмжлэг нь мөнгөн болон материаллаг, сэтгэл санааны зэрэг ямар ч хэлбэрээр байж болно. Баримт бичигт эдгээрийг ялгаж зааж өгөөгүйгээс сургууль, багш нар мөнгийг илүүд үзэж, мөнгөн хандив шаардаж байна. Түүнээс гадна сургуулиуд хэмжээний хувьд ялгаатай төлбөр, хураамж авч байгаа нь дээрх тушаалд ямар нэгэн хавсралт, удирдамж, зааварчилгаа байхгүйтэй холбоотой гэж үзэж болохоор байна.

Мөн тайланг зөвхөн багш тавихаар заасан нь учир дутагдалтай. Ихэнх тохиолдолд сургуулийн захиргаанаас багшаар дамжуулан хураадаг байтал сургуулийн захирал тайлагнах үүрэг хүлээлгээгүй байна. Энэ тохиолдолд багш сургуулийн захирлыг тайлагнахыг шаардах боломжгүй билээ. Эцэг эхчүүдээс хураасан төлбөр, хураамж сургуулийн санхүүгийн тайланд тусдаггүй тул сургуулийн захирал, нягтлан бодогч нар хэний ч өмнө хариуцлага хүлээдэггүй байна. Боловсролын газар, төрийн сангийн зүгээс эцэг эхээс оруулсан хувь нэмрийн тайланг шаарддаггүй. Боловсролын мэргэжлийн хяналт зөвхөн эцэг эхээс хууль бус төлбөр, хураамж авсан эсэхийг хянан шалгадаг.

Төсвийн тухай хуулийн дагуу сургуулиуд төрийн санд нэг л данстай байх ба тэрхүү дансанд орсон хөрөнгө маш хатуу хяналтын дор төрийн сангийн зөвшөөрлөөр батлагдсан төсвийн дагуу зарцуулагддаг. Тиймээс сургуулиуд эцэг эхээс хураасан төлбөр хураамжийг бэлнээр зарцуулж, сургуулийн дансанд тусгадаггүй. Нэгэнт сургуулийн дансанд тусгаж гүйлгээ хийгдээгүй тул захирал зарцуулалтын талаар хариуцлага хүлээдэггүй. Ихэнх тохиолдолд тайлангаа тавиад санхүүгийн баримтуудаа үзүүлэхээс татгалздаг байна. Эцэг эхийн хандив, тусламжаар худалдан авсан хөрөнгийг сургуулийн эд хөрөнгийн бүртгэлд бүртгэдэггүй. Зарим тохиолдолд тавилга, тоног төхөөрөмжийг шамшигдуулах тохиолдол гарч байна.

Эцэг эхийн хандив тусламжаар номын тавиур, хувцасны шүүгээ, ус буцалгагч, шал цонх худалдан авсан боловч дараа жил нь багштайгаа алга болсон. Бид нар дахин мөнгө хурааж, эдгээр зүйлсийг дахин худалдан авах хэрэгтэй болсон.

Эцэг эхийн төлөөлөл

Зөрчил гарахад өдөөж буй, үл итгэх байдлыг үүсгэж байгаа эмзэг байдал

Багшийн ёс зүйн дүрэмд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх; ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх; албан тушаалаа урвуулан ашиглахаас сэргийлэх; албадлага, дарамт үзүүлэхээс сэргийлэх; бэлэг сэлт, хээл хахууль авахаас сэргийлэх гэсэн таван чиглэлээр багш, сургуулийн удирдлага, бусад ажилтнуудын дагаж мөрдөх ёстой ёс зүйн хэм хэмжээг тодорхойлж өгсөн.

Сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтан дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

4.1. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх:

4.1.1. Хичээл, сургалтын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотойгоор хүүхэд, эцэг эх, олон нийт болон хамтран ажиллагчидтай хууль бус санхүү, эд хөрөнгийн харилцааг тэвчих;

4.1.3. Байгууллагын эд хөрөнгийг хувийн хэрэгцээнд ашиглахгүй байх;

4.1.4. Үндсэн ажлаас гадуур хууль тогтоомжоор зөвшөөрснөөс бусад давхар ажил, үүрэг эрхлэхгүй байх;

4.1.5. Хүүхэд болон эцэг, эх, асран хамгаалагчаас тоног төхөөрөмж, эд материал зэргийг худалдан авахыг ятгах, хууль бус орлого олохоос татгалзах;

4.2. Ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх:

4.2.1. Хүүхдийг гэр бүлийн байдал, хөгжил, суралцах чадвараар нь ялгаварлахгүй байх, сурлагын амжилтыг бодитойүнэлэх;

4.2.2. Эцэг, эх, асран хамгаалагч, олон нийт, хамтран ажиллагчдаа нас, хүйс, хувийн онцлог, албан тушаал, мэдлэг, туршлагаар нь ялгаварлахгүй, адил тэгш хүндэтгэлтэй хандах, хамт олны эв нэгдлийг дээдлэх;

4.4.5. Ном, сургалтын хэрэглэгдэхүүн, бусад зүйлийг тулган борлуулахгүй, хуульд заагаагүй төлбөр, хураамж, хандив өгөхийг шаардахгүй байх, хүлээн авахаас татгалзах;

4.3. Албан тушаалаа урвуулан ашиглахаас сэргийлэх:

4.3.1. Хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, хамтран ажиллагчдыг доромжлох, нэр төрийг гутаахгүй байх;

4.3.2. Хүүхдийн эрх, эрүүл мэндийг хохироох, амралт чөлөөт цагийг хасах замаар өөрийн ажлын амжилтыг урьтал болгохоос сэргийлэх;

4.4. Албадлага, дарамт үзүүлэхээс сэргийлэх:

4.4.3. Хүүхдийн дунд сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаа явуулахдаа сургууль, цэцэрлэгийн нэрийг барьж хүчээр албадахгүй байх;

4.4.4. Чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хувийн үзэл бодол, улс төрийн байр сууриа хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, хамт олонд тулган хүлээлгэхгүй, уриалахгүй байх;

4.4.5. Ном, сургалтын хэрэглэгдэхүүн, бусад зүйлийг тулган борлуулахгүй, хуульд заагаагүй төлбөр, хураамж, хандив өгөхийг шаардахгүй байх, хүлээн авахаас татгалзах;

4.5. Бэлэг сэлт, хээл хахууль авахаас сэргийлэх:

4.5.1. Ажил, үүргээ гүйцэтгэсний төлөө сурагч, эцэг эхээс шан харамж, хээл хахууль авах, өгөхөөс татгалзах, зуучлахгүй байх;

4.5.2. Төгсөлт, элсэлт зэрэг албан ёсны арга хэмжээ, баяр ёслолын үед хүүхэд, тэдний асран хамгаалагч, эцэг эхийн зөвлөлийг үнэтэй бэлэг өгөхөөс аргагүй байдалд хүргэхгүй байх;

4.5.3. Хуульд заасан төлбөр, хураамж, хандив, хөрөнгийн зарцуулалттай холбоотой тайлан мэдээг цаг тухайд нь шударга, ил тод тайлагнадаг байх;

Зөрчлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлд Боловсролын тухай хууль зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах тухай заалт байдаг. Хуулийн 9.1.1. дүгээр зүйлд суралцагчид сэтгэл санааны дарамт үзүүлсэн, эсхүл мөнгө өгөх, ном, бүтээгдэхүүн худалдаж авахыг тулгасан, эсхүл хуульд заагаагүй төлбөр, хураамж авсан бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор; 9.1.5. дугаар зүйлд хуульд заасан тусгай зөвшөөрөл аваагүй, эсхүл боловсролын сургалтын байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэлгүй боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхэлсэн бол хууль бусаар олсон орлогыг хурааж, учруулсан хохирол нөхөн төлбөрийг гаргуулж, сургалтын төлбөрийг суралцагчид буцаан олгож хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заажээ.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд төрийн албан хаагч өөрт олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй аливаа нөхцөл байдлаас татгалзах заалтууд орсон ба өөрийн хөрөнгө, орлогын байдал, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаар эрх бүхий байгууллагад үнэн зөв мэдээлэх үүрэг оноожээ. Уг дүрэмд төрийн албан хаагч ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлаар эцэслэн дүгнэж, шийдвэр гаргах эрх бүхий Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын дэргэд ажиллахаар заасан ч ярилцлагад оролцсон хүмүүс энэ талаар мэдээлэлгүй байсан ба дотоод хяналтын зөвлөлийн талаар илүү мэдээлэлтэй байгаа нь харагдсан.

Орон нутгийн түвшинд, тухайлбал Өвөрхангай аймагт фокус бүлгийн ярилцлага ба ганцаарчилсан ярилцлагад оролцогчид эрүүл мэнд, боловсролын салбартай холбоотой санал гомдлууд тусгай зориулалтын утсаар ирдэг бөгөөд хяналт шалгалтын үеэр гаргадаг гомдлын дийлэнх сургууль, багш нарын эцэг эхчүүдээс хурааж байгаа мөнгөний талаар байдаг гэжээ. Тэгэхээр нэг талаар Боловсролын сайдын 2019 оны А/508 дугаар тушаал нь эдгээр гомдлыг гаргахгүйн тулд эцэг эхээс мөнгө хураах явдлыг албажуулсан гэж харагдаж байна. Орон нутгийн удирдлагууд энэ тушаалыг мэдэж байгаа боловч бусад төрлийн төлбөр, хураамжийг үргэлжлүүлэн авсаар байна.

Боловсролын яамны статистикийг харвал ДНБ-д эзлэх боловсролын зардлын хувь хэмжээ 2010-2018 онуудад 6,1-ээс 4,3 хувь болж буурсан байна. 1990 оноос хойш боловсролд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ асар доогуур явж ирсэн ба 2018 оны төсвийн жилээс огцом нэмэгдсэн нь

сургууль ба цэцэрлэгийн өсөн нэмэгдэж байгаа эрэлт хэрэгцээг хангах өөрөөр хэлбэл, сургууль цэцэрлэгийн барилгыг шинээр барихад зориулагдсан.

Нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаар сургууль санхүүжигдэх бөгөөд энэхүү хувьсах зардлын хэмжээг жил бүр Засгийн газраас шинэчлэн тогтоох ёстой байтал 2016 оноос хойш шинэчлээгүй байна. Энэ нь сургуулийн удирдлагуудыг төсвийн дутагдлыг эцэг эхийн хандив тусламжаар нөхөхөөс өөр аргагүй байдалд хүргэж байгаа гэж хэлж болно. Боловсролын төсвийн тойм судалгааны үр дүнгээс харахад ЕБС-ын төсвийн 70 хувь нь багшийн цалинд, 20 орчим хувь нь тогтмол зардалд, зөвхөн 2 хувь нь сургалтын хэрэглэгдэхүүн, бичиг хэрэгт зарцуулагдаж байна. Сургалтын үндсэн үйл ажиллагааны төсөв маш доогуур байгаа нь сургалтын чанарыг сайжруулахад тулгарч байгаа гол саад бэрхшээл болж байна.

“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслээс хийсэн “Сургуулийн төсвийг мөшгөх судалгааны” дүн шинжилгээнээс харахад сургуулийн төсөв бодитой төлөвлөгддөггүй, боловсролын үйлчилгээг үр дүнтэй хүргэхэд хангалттай биш байгаа нь харагдаж байна. Сургуулиудын зөвхөн 3% нь багшийг хичээл сургалтын хэрэглэгдэхүүнээр бүрэн хангадаг бол, 47% нь ямар ч зардал гаргадаггүй байна. Багш нарын 36% нь хичээл сургалтдаа бэлдэхийн тулд эцэг эхчүүдээс дэмжлэг авдаг. Сургалтын хэрэглэгдэхүүн, материал, лабораторийн тоног төхөөрөмж, сургалтын зорилготой аялал, бичиг хэрэглэлийн зардал, ном хэвлэл, засвар үйлчилгээ, цэвэрлэгээний материал, хичээлээс гадуурх үйл ажиллагааны төсөв маш бага тул эцэг эхийн хандив, тусламжийг авахад хүргэж байгааг дахин баталгаажуулсан байна. Эдгээр төсвийн зүйл ангид тусгагдсан төсөв Боловсролын төсвийн тойм судалгаагаар 2013-2017 онуудад жил бүр хасагдах хандлагатай байгааг харж болно. Сургуулийн үйл ажиллагааны зардалд хуваарилж байгаа төсвийн хэмжээтэй харьцуулахад эцэг эхийн хувь нэмэр багийн сургуулиудад маш бага байгаа бол томоохон аймаг, Улаанбаатар хотын сургуулиудад их хэмжээтэй байна.

Дөрөвдүгээр бүлэг. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

2018 онд Азийн сангаас хийсэн судалгааны тайланд авилгаас урьдчилан сэргийлэхийн тулд төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх, захиргааны шийдвэр гаргалтын ил тод байдал, төрийн захиргааны байгууллагат тавих хяналтыг бэхжүүлэх, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, төрийн захиргааны байгууллагат тавих төрийн бус байгууллагын хяналтыг бэхжүүлэх, хууль хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагаануудыг санал болгосон. Энэхүү судалгааны хүрээнд дээрх зөвлөмжүүдэд үндэслэн дараах чиглэлүүдэд анхаарч ажиллахыг зөвлөж байна.

Тэргүүлэх чиглэл 1: Өдөр өнжүүлэх үйлчилгээний эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Бүтэн цагаар ажил хөдөлмөр эрхэлдэг эцэг эхчүүд өөрийн хүүхдийн ангийн багшийн зохион байгуулдаг өдөр өнжүүлэх төвүүдэд бага сургуулийн насны хүүхдүүдээ хамруулахаас өөр аргагүй байдалд байна. Гэтэл эдгээр төвөөр үйлчлүүлж байгаа эцэг эхчүүд төвийн орчин нөхцөл, үйлчилгээнд сэтгэл ханамжгүй байгаа нь тэдний ашиг сонирхлыг хамгаалах зохицуулалт байхгүй байгаатай холбоотой байна.

Өдөр өнжүүлэх төвийн үйл ажиллагаанд илүү уялдаа холбоотой цогц зохицуулалтыг хийх тухайлбал, маш тодорхой нарийвчилсан дорвитой стандарт, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг батлах хэрэгцээ байна. Ялангуяа сургуульд бүтэн цагаар ажилладаг багш, ажилтнууд хувиараа нэмэлт үйлчилгээ үзүүлж байгааг зохицуулах шаардлага тулгамдаж байна. Дээрх зохицуулалтаас гадна эцэг эхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, байнгын хяналт шалгалт хийх чиглэлээр дүрэм журам гаргаж хэрэгжүүлэх нь чухал байна.

Тэргүүлэх чиглэл 2: Орон нутгийн төвшинд тусгай зориулалтын утасны үйлчилгээг үр дүнтэй ажиллуулах.

Боловсролын салбар дах авлигатай холбоотой зөрчлийн олон хэлбэр сургуулийн түвшинд гарч байгаа нь зарим орон нутагт нэлээд түгээмэл тохиолдож, улмаар сөрөг нөлөө үзүүлж эхэллээ. Эдгээр асуудлыг боловсролын төрийн захиргааны байгууллага хүлээн авч шийдвэрлэх бүрэн эрх нь байгаа ч дээрх асуудлын эмзэг байдлаас шалтгаалан эцэг эх, олон нийт мэдэхгүй, эсвэл мэдээлэх үүргээ биелүүлж чадахгүй байна.

Үр дүнтэй, шуурхай ажилладаг тусгай утасны үйлчилгээг орон нутагт нэмэгдүүлэх хэрэгтэй бөгөөд нийтэд тустай байх болно. Энэхүү үйлчилгээтэй холбоотой дүрэм журмыг боловсруулан олон нийтийн мэдлэг ойлголтыг

нэмэгдүүлснээр эцэг эхийн гомдол, санал орон нутгийн болон аймаг, нийслэлийн засаг захиргаанд түргэн шуурхай хүрч шийдвэрлэгдэх нөхцөл бүрдэнэ. Зарим орон нутагт сайн жишиг тогтсон байгааг улам сайжруулж, үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх нь зүйтэй.

Тэргүүлэх чиглэл 3: Төрийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийдэг үндэсний тогтолцоог бэхжүүлэх.

Боловсролын тогтолцоонд бодлого, чиглэл нь ойрхон өөрчлөгдөж, хүний нөөцийн тогтворгүй байдал газар авсантай холбоотойгоор боловсролын салбарт батлагдсан дүрэм журмын хэрэгжилт хангалтгүй байна. Энэхүү хийдлийг ашиглан сургуулийн захирал, багш нар авлигын үйлдэл, хууль бус үйл ажиллагаа явуулж байгааг анхаарах шаардлагатай байна. Боловсролын салбарт бодит өөрчлөлтүүдийг хийж эхлэх, хариуцлага, ил тод байдлыг сайжруулах, бодлогыг нь газар дээр нь хэрэгжүүлэх, үнэлэх зэргээр боловсролын засаглалыг сайжруулах нь амин чухал байна.

Энэ зорилгоор боловсролын яамны дэргэд бодлогын хяналт-шинжилгээний үүрэг гүйцэтгэдэг бүтцийг байгуулж, бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээг тогтмол хийх шаардлагатай байна. Энэ бүтцийн эн тэргүүнд хийх ёстой ажил нь Боловсролын хүрээлэн болон бусад оролцогч талтай зөвлөлдсөний үндсэн дээр бодлогын хэрэгжилтийг үнэлж хянах шалгуурыг боловсруулах юм. Энэхүү бүтэц нь боловсролын бодлого, стратеги, төлөвлөгөө, хөтөлбөрүүдийн үнэлгээ, хяналт-шинжилгээ хийх, одоо байгаа үндэсний тогтолцоо хүрээг хянаж үнэлэн, хэрэгжилтийн үйл явцыг баталгаажуулах, хяналт-шинжилгээ хийх хариуцлага хүлээсэн гол түнш эсвэл оролцогч талуудаа тодорхойлж хамтран ажиллах явдал юм. Тэд ажлаа боловсролын мэргэжлийн хяналтын үйл ажиллагаатай уялдуулах шаардлага байна.

Тэргүүлэх чиглэл 4: Орон нутгийн ба түүнээс дээших түвшинд ажиллаж байгаа ёс зүйн зөвлөлийг бэхжүүлэх.

Ёс зүйн зөвлөл сургуулийн түвшинд байгуулагдаад 10 орчим жил өнгөрлөө. Өнгөрсөн хугацаанд багшийн ёс зүйн алдаа, зөрчилтэй холбоотой маш цөөн гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Гомдол ирэхгүй байна гэдэг асуудал байхгүй гэсэн үг биш. Эцэг эх болон иргэдээс ирүүлсэн гомдлыг зохих ёсоор шалган үзэж, шийдвэрлэж чадахгүй байгаа нь сургуулийн түвшин дэх зөвлөлийн чадавх сул байгаатай болон шийдвэрлэж байгаа тохиолдлуудын мөн чанартай холбоотой. Ёс зүйн зөвлөлүүд хянан шийдвэрлэх үүргээ гүйцэтгэж чадахгүй, авлига, ёс зүйн алдаатай үйлдэлд

тохирох шийтгэл оноож чадахгүй байна.

Дүүрэг болон аймаг, үндэсний түвшинд байгуулагдсан ёс зүйн зөвлөлийн чадавхыг бэхжүүлснээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд дөхөм болно гэж үзэж байна. Сургуулийн дүрэм, багшийн ёс зүйн дүрэм, төрийн албан хаагчдын ёс зүйн дүрэм болон бусад хууль, тогтоомж нэлээд цогц байдлаар хэрэгжиж байгаа тул багшийн ёс зүйн дүрмийг хатуу мөрдүүлэх, байгуулагдсан ёс зүйн зөвлөлүүдийг бэхжүүлэх нь зүйтэй байна.

Тэргүүлэх чиглэл 5: Сургуулийн засаглалд эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх.

Монгол Улс дахь ЕБС-ийн 70% нь орон нутгийн жижиг сургууль байдаг. Улаанбаатар хотын сургуулиудтай харьцуулахад дээрх сургуулийн эцэг эхчүүд бичиг үсэггүй, ажил хөдөлмөр эрхэлдэггүй, өөрөөр хэлбэл эрх мэдэлгүй эцэг эхчүүд байдаг. Багш, сургуулийн удирдлагын ёс зүйгүй үйлдэл, зан авир нь эцэг эхийн байгууллага, сургуулийн зөвлөлийн хяналтаас гадуур байдаг гэсэн үг. Сургуулийн үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх нь урт хугацаанд боловсролын салбарт шийдэгдээгүй асуудал бөгөөд сургуулиудын алслагдмал байдлаас болоод холбогдох байгууллага, эрх мэдэлтнүүдийн хяналт шалгалтад тэр бүр хамрагддаггүй нөхцөл байдлаас шалтгаалан эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байна.

Эцэг эхийн оролцоо сургуулийн шийдвэр гаргах түвшинд баталгаажиж, боловсролын тогтолцооны нийгмийн эгэх хариуцлагын нэг чухал хэсэг болох шаардлага тулгарч байна. Хэдийгээр эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх боломжийг нээх эрх зүйн баримт бичиг эхнээсээ батлагдан гарч байгаа ч эцэг эх олон нийт нь сургуулийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, шийдвэр гаргахад оролцох сайн туршлагыг цуглуулж түгээх хэрэгцээ байна. Ингэснээр эцэг эхийн хандив, төлбөр, хураамжтай холбоотой зарцуулалтыг ил тод болгох тал дээр ахиц дэвшил гарна гэж үзэж байна.

Тэргүүлэх чиглэл 6: Боловсролын төсөв, санхүүжилтийг нэмэгдүүлэх.

Хөрөнгө оруулалтын болон урсгал зардал маш бага байгааг судалгааны дүнгүүд харуулж байна. Урсгал зардлын дотор засвар үйлчилгээний зардал гэдэгт засварын зардал багтдаг ба 2005-2018 онуудад урсгал зардлын 0,02 хувиас дээш гарч байгаагүй байна. Боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн мэдээлснээр анги танхимд хэрэглэдэг хичээл сургалтын материалын зардал туйлын бага, боловсролын төсвийн урсгал зардлын 1

хувиас ихгүй байна. Анги засвар, сургалтын хэрэглэгдэхүүн, материалын төсөв үнэхээр хязгаарлагдмал байгаагаас шалтгаалан сургуулиуд эдгээр зардлаа эцэг эхийн хандив, тусламж, орон нутгийн төсвийн хөрөнгө, олон улсын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр шийдэхээс өөр аргагүй байдалд орж байна.

Боловсролын санхүүжилтийг боловсролын үйлчилгээг чанартай хүргэхэд шаардагдах хэмжээнд нэмэгдүүлэх болон сургуульд хуваарилагдаж байгаа төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх гэсэн хоёр асуудалд зэрэг анхаарах хэрэгтэй байна. Салбарын стратеги бодлогын чиглэл, үндэсний болон олон улсын түвшинд авсан амлалтуудын хүрээнд санхүүжилтийн байдлыг хянан үзэж, багш нарын цалин хөлс, сайн сайхан байдал, нийгмийн хамгаалал, сурагчдын аюулгүй байдал, хамгаалалд зориулах зардлыг боломжит түвшинд хүргэх хэрэгтэй байна. Сургуулийн засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжийн зардлыг төсөвт хангалттай хэмжээгээр тусгаж, эцэг эх, асран хамгаалагчаас цуглуулдаг хандивыг зогсоох шаардлагатай байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

БСШУСЯ, 2018. Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, албан бус ба насан туршийн боловсролын төвийн багш, удирдах ажилтнуудын ёс зүйн дүрэм.

УИХ, 1992 Монгол Улсын Үндсэн хууль.

Белградын Их сургууль, 2017. “Үндэсний цөөнхийн багш нар Серби дэх Ромачууд-боловсролын шинэчлэл” Философийн факультет, сэтгэл судлалын сургууль

Авлигатай тэмцэх газар, 2018. “Шударга байдлын үнэлгээ”

“Тэгш хамруулах боловсролын оролцогч талуудын авлигын үйлдлүүдийн талаарх туршлагаа хүүрнэсэн нь” 2019

УИХ, 2006. Авлигатай тэмцэх тухай хууль

УИХ, 2017. Төрийн албаны тухай хууль

УИХ, 2002. Боловсролын тухай хууль

УИХ, 2014. Шилэн дансны тухай хууль

УИХ, 2012. Төрийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хууль

“Боловсрол дах хүлээлт үл итгэх байдал ба авлигал: боловсролыг сайжруулах замаар урьдчилан сэргийлэх арга зам”. 2020

БНБТИНҮЭ, 2015. “Бага боловсролын цөм хөтөлбөрийн хэрэгжилт, зохицуулалтад хийсэн мониторингийн тайлан”

Дэлхийн банк, 2018. “Монгол улс: Өр зээлгүйгээр өсөж дэвжих нь” Төсвийн зарцуулалтын тойм судалгаа.

УИХ, 2016. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр

ЭЗХХАБ, 2018. “Боловсролын тогтолцооны шударга байдал”. Салбарын үнэлгээний аргачлал

Засгийн газар, 2019. Төрийн захиргааны болон үйлчилгээний ажилтнуудын ёс зүйн дүрэм

ГБХЗХГ, 2018. Өдөр өнжүүлэх төвүүдийн нөхцөл байдлын дүн шинжилгээний тайлан

МХЕГ, 2019. Сургуулийн үнэлгээний хуудас

БСШУСЯ, 2010. ЕБС-ын үлгэрчилсэн дүрэм

Нийгмийн сүлжээний материалууд (Eagle news)

Азийн сан, 2016. Авлигын талаарх мэдлэг, төсөөллийг тандах судалгаа

Азийн сан, 2018. Авлигын талаарх мэдлэг, төсөөллийг тандах судалгаа.

БХАН, Колумбын Их Сургуулийн Багшийн коллеж, 2013. Нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн стратеги: ерөнхий боловсролын сургуулийн санхүүжилтийн томъёонд хийсэн империк судалгаа

Азийн сан, 2017. Монгол Улсын боловсролын салбар дах ил тод байдал, ёс зүй, авлигын асуудлууд

Ковач Церович, Т. Жованович, М, 2019. Тэгш хамруулах боловсролд оролцож буй оролцогчдын хүүрнэсэн авлигын үйлдлүүдийн талаарх болон түүний эргэн тойрон дах туршлага, Гамбург, 2019: Эрсдлийн нөхцөл дэх боловсрол-ирээдүйд боловсролын судалгааны гүйцэтгэх үүрэг. 2020 оны 1 сарын 26-нд татан авсан. <https://eera-ecer.de/ecer-programmes/conference/24/contribution/48922/>

Милованович, М. 2020. Боловсрол дах үл итгэлцэл ба авлига: Боловсролыг сайжруулах замаар урьдчилан сэргийлэх нь судалгааны үр дүнгүүд. Харьцуулсан боловсрол судлалын өнөөгийн асуудлууд. 21-р дугаар, Дугаар 1, 54-68